



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 881

Улаанбаатар хот

Г Техникийн комисс байгуулах, журам
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлاغнах журам” батлах тухай 264 дүгээр, Сангийн сайдын 2012 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам” батлах тухай 290 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг эцсийн хэрэглэгч байгууллагын хүлээн авах комисс ажиллахаас өмнө “Эмнэлгийн тоног төхөөрөмжийг туршилтаар ажиллуулж шалгалт хийх, гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолт хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах” техникийн комиссыг нэгдүгээр, “Мэдээллийн технологийн болон бусад тоног төхөөрөмжийг туршилтаар ажиллуулж шалгалт хийх, гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолт хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах” техникийн комиссыг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Техникийн комиссын үйл ажиллагааны журмыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

3. Техникийн комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга /Л.Зэндмаа/, Хяналтшинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /С.Төгсдэлгэр/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 328 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

030266

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 03 сарын 15 өдрийн
181 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг эцсийн хэрэглэгч байгууллагын хүлээн авах комисс ажиллахаас өмнө “Эмнэлгийн тоног төхөөрөмжийг туршилтаар ажиллуулж шалгалт хийх, гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолт хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах” техникийн комиссын бүрэлдэхүүн

Техникийн комиссын дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга
Л.Зэндмаа

Нарийн бичгийн дарга: Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн Техник технологийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн О.Баяржаргал

Гишүүд:
Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн техник, технологийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Н.Гэрэлт-Од

Санхүү эдийн засгийн хэлтсийн Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Сансармаа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хариуцсан мэргэжилтэн Р.Энхсүрэн

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Б.Санж-Очир

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээлэл, судалгааны нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэн Б.Батцоож

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 08 сарын 15
18 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг эцсийн хэрэглэгч байгууллагын хүлээн авах комисс ажиллахаас өмнө “Мэдээллийн технологийн болон бусад тоног төхөөрөмжийг туршилтаар ажиллуулж шалгалт хийх, гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолт хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах” техникийн комиссын бүрэлдэхүүн


Техникийн комиссын дарга: Хяналт –шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр

Нарийн бичгийн дарга: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн М.Насанбаян

Гишүүд: Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Х.Хүрэлбаатар

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Салбарын цахим сан, програм хангамж хариуцсан мэргэжилтэн Ж.Эрдэнэ-Очир

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны Мэдээллийн технологи, телемедициний тоног төхөөрөмж, програм хариуцсан мэргэжилтэн Л.Мөнхбаяр



ТЕХНИКИЙН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжийг эцсийн хэрэглэгч байгууллагын хүлээн авах комисс ажиллахаас өмнө туршилтаар ажиллуулж шалгалт хийх, гэрээнд тусгагдсан техникийн тодорхойлолт хангаж буй эсэхийг хянах, баталгаажуулах үйл ажиллагаанд баримтална.

1.2 Эрүүл мэнд, спортын сайдын тушаалаар томилогдсон техникийн комисс /цаашид “техникийн комисс” гэх/ хяналт, шалгалт, туршилтын үр дүнг тайлгаха, техник үзүүлэлт хангаж буй эсэхэд урьдчилсан дүгнэлт гаргана.

Хоёр. Техникийн комиссын зохион байгуулалт, эрх, үүрэг

2.1 Техникийн комиссын нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулиуд болон Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам, энэхүү журмыг удирдлага болгоно.

2.2 Техникийн комисс нь техникийн комиссын дарга, техникийн комиссын нарийн бичгийн дарга болон холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн байна.

2.3 Техникийн комиссын үйл ажиллагааны хэлбэр нь нийлүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирсэн хүсэлт, гэрээ болон хавсаргасан материалуудыг үндэслэн нийлүүлэгчийн агуулах, эцсийн хэрэглэгчийн байранд очиж хяналт, шалгалт, туршилт хийх болон ажлын хэсгийн хурал байна.

2.4 Газар дээр нь хянаж шалгахдаа дараах ажиллагааг хэрэгжүүлнэ:
2.4.1 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжүүдийн татан авалт, нийлүүлэлтийн явц, хадгалалтын нөхцөлтэй танилцах

2.4.2 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжүүдийн техник үзүүлэлтийг гэрээнд тусгагдсан техник үзүүлэлттэй тулгалт хийх

2.4.3 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй тоног төхөөрөмжүүдийн техник үзүүлэлтийг тухайн тоног төхөөрөмжийн дагалдаж ирсэн паспорт, бичиг баримттай тулгалт хийх

2.4.4 Шаардлагатай тохиолдолд Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжүүд дээр шалгалт тохируулга хийх симулятор болон анализатор ашиглан дүгнэлт гаргах /Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба/

2.5 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллагаас тухайн тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтын хөтөлбөрийг батлуулан гаргуулж, хянах

2.6 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллагаас тухайн тоног төхөөрөмжийн монгол хэл дээр хөрвүүлсэн ашиглалтын гарын авлага, засвар үйлчилгээний хуваарь, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг баталгаажуулан гаргуулж, хянах

2.7 Хяналт, шалгалт, туршилтаар зөрчил илрээгүй тоног төхөөрөмжүүд дээр гэрээний дагуу татан авалт хийгдсэн, техникийн тодорхойлолт хангасан, эцсийн хэрэглэгчийн хүлээн авах комисс ажиллахад бэлэн болсон тухай урьдчилсан дүгнэлт гаргаж өгнө.

2.8 Техникийн комисс нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн албан тоотыг хүлээн авснаас хойш ажлын 10 - 14 хоногийн дотор тухайн байгууллагын тоног төхөөрөмжтэй танилцаж, туршилтаар ажиллуулж хяналт, шалгалт хийж, техникийн тодорхойлолт хангаж буй эсхэд урьдчилсан дүгнэлтийг гаргана.

2.9 Захиалагч нь техникийн комиссын урьдчилсан дүгнэлтийг үндэслэн шалгалт, туршилтаар техникийн тодорхойлолтыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу тоног төхөөрөмжөөс татгалзах, нийлүүлэгчээс тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх арга хэмжээ авч ажиллахыг шаардах эрхтэй.

Гурав. Эцсийн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллага болон нийлүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг

3.1 Эцсийн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэнд, спортын сайдын хөрөнгө хуваарилалтын тушаал, техникийн комиссын урьдчилсан дүгнэлт, захиалагч болон гүйцэтгэгч хооронд байгуулсан гэрээ, холбогдох хууль тогтоомж зэргийг үндэслэн тоног төхөөрөмжийг хүлээн авах комисс байгуулан, эцсийн хүлээн авалт хийж “Тоног төхөөрөмж хүлээн авсан комиссын актыг Сангиин сайдын 2012 оны 290 дугаарын тушаалын 6-р хавсралтын дагуу үйлдэж” үр дүнг танилцуулна.

3.2 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллага нь урьдчилсан дүгнэлтээр зөвшөөрөл олгогдсоны дараа тухайн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтыг бүрэн хийж, холбогдох сургалтыг зохион байгуулж, ашиглалтад бүрэн оруулсны дараа эцсийн хэрэглэгч байгууллагын хүлээн авах комиссад хүлээлгэн өгнө.

3.3 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 3.3.1 Тоног төхөөрөмж нийлүүлэхэд бэлэн болсон тухай албан тоот
- 3.3.2 Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт /Гэрээнд тусгагдсан/
- 3.3.3 Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон засвар үйлчилгээний сургалтын хөтөлбөр, батлагдсан хуваарь
- 3.3.4 Баталгаат засварын хугацаан дахь засвар үйлчилгээ, тохиргооны батлагдсан хуваарь
- 3.3.5 Гарын авлага, удирдамж (Монгол хэл дээр)
- 3.3.6 Сэлбэг хэрэгслийн жагсаалт, үнийн хамт
- 3.3.7 Үйлдвэрлэгчээс гаргасан холбогдох ном, гарын авлага, танилцуулга

Дөрөв. Хамрах хүрээ:

4.1 ЭМСЯ-ны харьяа Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд

4.2 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд

4.3 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллагууд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд

Тав. Үр дүн:

Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч байгууллагуудаас эцсийн хэрэглэгч байгууллын хүлээн авах комисс ажиллахаас өмнө баримт бичгийн болон бусад хяналт, шалгалт, туршилт хийгдсэн байна.

Зургаа. Үйл ажиллагааны хүн хүчин:

6.1 Техникийн комиссын бүрэлдэхүүн

6.2 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар тоног төхөөрөмж нийлүүлэгч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллүүд

6.3 Эцсийн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагууд, хүлээн авах комисс

6.4 Эрүүл мэнд, спортын сайдын батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөр, зээл, хандив тусlamжаар нийлүүлэгдэж буй эмнэлгийн тоног төхөөрөмжүүд дээр шалгалт тохируулга хийх симулятор болон анализатор ашиглан дүгнэлт гаргах /Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба/